



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2026/12/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас:7034-2580 Цахим хаяг: [Bulgan@audit.gov.mn](mailto:Bulgan@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас:9905-7478 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас:9907-9641 Цахим хаяг: [Tserenlhamg@audit.gov.mn](mailto:Tserenlhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

1026-00 Д/Н № 252

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

Г МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА Г  
Г.ОДСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ илүү цагаар гүйцэтгэсэнд 18.0 сая, МЭЕГ-ын даргын шийдвэргүй, аймгийн Засаг даргын захирамжаар газрын даргад 1.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,
- Газрын дарга эрх бүхий албан тушаалтнаар томилолтын зардал (нөхөх төлбөр) олгох тухай эрх зүйн шийдвэргүй, гадаад томилолтыг аймгийн ТЭЗ-аас олгосон байхад давхардуулан өөртөө тушаал гаргаж 0.9 сая, албан томилолтоор ажиллах хугацаанд албан хаагчдад нөхөн төлбөр 1.1 сая төгрөг нийт 2.0 сая төгрөгийг зөрүүтэй тооцож олгосон,
- Шатахууныг жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулсан, автомашины спидометрийн заалт зөрүүтэй, анхан шатны баримтгүй 2.3 сая төгрөгийг зарцуулсан,
- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын "Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн бүтэц, орон тоо, төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" 2025 оны А/342 дугаар тушаалаар Хангал, Сэлэнгэ, Орхон, Сайхан,Тэшиг сумдын тархвар зүйчийн хасагдсан орон тоонд нэр бүхий 4 албан хаагчид тухайн сумын ажлыг хавсран гүйцэтгүүлж 7.0 сая төгрөг олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч тархаагүй байна.

6326050740

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол, асгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол, Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал, Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны 8 дугаар хуралдааны 55 дугаар тогтоолуудтай тус тус нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/34 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Гамшгаас хамгаалах Улсын албаны команд штабын сургуулилтад анх удаа улсын хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 14-нөөс 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцсон байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аймгийн хэмжээнд 2025 онд 11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,387.4 мянган толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	470,943.3	1,505,353.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	441,703.6	470,592.6
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>912,646.9</b>	<b>1,975,946.5</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,495,475.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	912,646.9	480,470.9
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>912,646.9</b>	<b>1,975,946.5</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	6,463,789.3	4,669,886.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	6,480,548.2	5,093,972.9
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(16,758.9)</b>	<b>(424,086.2)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(8,089.9)
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(16,758.9)</b>	<b>(432,176.1)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	929,405.9	912,647.0
	Тайлант оны үр дүн	(16,758.9)	(432,176.1)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>912,647.0</b>	<b>480,470.9</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,922,784.2	3,220,718.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,879,446.8	3,196,065.4
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>43,337.4</b>	<b>24,652.7</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(43,337.4)</b>	<b>(24,652.7)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	-	<b>1,831,033.3</b>
	Урсгал зардал	-	1,831,033.3
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	-	<b>1,831,033.3</b>
	Улсын төсвөөс санхүүжих	-	1,822,236.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	8,796.9

Мал эмнэлгийн газар нь эрхэм зорилгоо “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхээр малын эмч нарыг чадавхжуулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын бруцеллёз, боом, галзуу зэрэг зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдлын лаборатори, чанарын дэд бүтцийг сайжруулах чадавхжуулах, үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархинагтах өвчингүй, тайван байдлыг ДМАЭМБ-аар баталгаажуулах, шүлхий өвчингүй болгоход чиглүүлэн ажиллажээ.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн засаг даргын 2025 оны А/815 дугаар захирамжаар 87.5 хувьтай үнэлүүлэн “хангалттай” үнэлгээг МЭЕГ-т хүргүүлсэн байна.

Байгууллага нь үйл ажиллагаандаа Авлигын эсрэг хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Салбарын хувьд Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль, Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малыг генетик нөөцийн тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хүнсний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” зэрэг хууль, тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тайлант онд хөндлөнгийн байгууллага болон Мал эмнэлгийн Ерөнхий газраас дотоод хяналт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/34 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Гамшгаас хамгаалах Улсын албаны команд штабын сургуулилтад анх удаа улсын хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 14-нөөс 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцсон байна.

Аймгийн хэмжээнд 2025 онд 11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,387.4 мянган толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **Тав. Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс хавсралт файлыг нэгдүгээр сараас бусар саруудад мэдээлээгүй, холбогдох мэдээллийг хавсралт файл буюу нотлох баримтыг

мэдээлээгүй, батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал мэдээлээгүй, бөөн дүнгээр нь мэдээлсэн, байгууллагын ерөнхий мэдээлэл дутуу мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Мэдээллийн иж бүрэн байдал, үнэн зөв, мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах, хяналт хариуцлагыг дээшлүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### **Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**Илрүүлэлт 1:** Архив албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас болон үнэт цаасны тайлан хийж ажиллаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын албан тоот, тушаал гэх мэт хэвлэмэл болон улсын байцаагчийн үнэт цаасыг бодитоор тоолж, тайланг хариуцсан ажилтнаар гаргуулж хэвших зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төрийн үйлчилгээний албан хаагчдад үр дүн, ур чадварын нэмэгдлийг газрын даргын шийдвэргүй сар бүр олгосон, эмийн тайланд бруцеллез штам-19 22.58 тун, бруцеллез рев-1 169.4 тун, шингэлэгч 174.7 л хугацаа дууссан вакцин, үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 30 нэр төрлийн 46.658.378 төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна. Шалгагдагч байгууллагын гадна талын үүдэнд төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, үр ашиггүй, хүрэн вакум хаалтыг зээлээр хийлгэн байна.

Иймд дараагийн аудитаар анхаарах асуудалд МЭЕГ-ын даргаар үндсэн хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох шийдвэрийн талаар арга яаралтай ТӨБЗГ-аар эрх зүйн шийдвэр гаргуулахад арга хэмжээг зохион байгуулахад чиглэсэн зөвлөмжийг хүргүүлэх, өмнөх онд зээлээр хийгдсэн гадна вакум хаалганы ажил гүйлгээ дараагийн онд хийгдсэн эсэхийг нягтлан шалгаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **Найм. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 78.0 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 78.0 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Аудитаар нийт 89.9 сая төгрөгийн 10 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 24.2 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.1 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 52.6 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 89.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 43.0 сая төгрөгөөр давсан, материаллаг зөрчил өргөн тархалттай тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

## 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Эрх бүхий албан тушаалтнаас илүү цагаар ажиллуулах шийдвэргүй, албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ илүү цагаар ажиллаж хийсний төлөө 7 удаагийн газрын даргын тушаалаар нэмэгдэл хөлс олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам, Булган аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалаар баталсан "Мал эмнэлгийн газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.1 дэх заалт нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагаар ажиллах ажил олгогчийн шийдвэр гараагүй, үндсэн чиг үүргийн ажлаа илүү цагаар гүйцэтгэж, нэмэгдэл цалин олгосон 18.1 сая төгрөгийн зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 2: Газрын дарга эрх бүхий албан тушаалтнаар томилолтын зардал (нөхөх төлбөр) олгох тухай эрх зүйн шийдвэргүй, өөртөө тушаал гаргасан, томилолтын удирдамж, гүйцэтгэл зөрүүтэй, гадаад томилолтыг аймгийн ТЕЗ-аас олгосон байхад 3 удаагийн томилолтын зардал 0.9 сая төгрөгийг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтоор ажилласан хугацаанд олгосон хоолны мөнгийг давхардуулан олгосон зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 3: Томилолтоор ажиллах хугацаанд хоол, унааны мөнгийг албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг 3 албан хаагчдад 0.3 сая төгрөг дутуу олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтоор ажилласан хугацаанд олгосон хоолны мөнгийг давхардуулан олгосон зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 4: Томилолтоор ажиллах хугацаанд хоол, унааны мөнгийг албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг 21 албан хаагчдад 0.9 сая төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтоор ажилласан хугацаанд олгосон хоолны мөнгийг давхардуулан олгосон зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 5: Аймгийн Засаг даргын 2025 оны А/815 захирамжаар газрын дарга Г.Одсүрэнд 12 дугаар сард үр дүнгийн урамшуулал 1.7 сая төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилсон эрх бүхий албан тушаалтны урамшууллыг шийдвэргүй олгосон 1.7 сая төгрөгийн зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 6: Жолоочийн тооцооны хуудасгүй, анхан шатны баримтгүй, автомашины шатахуун зарцуулах нормыг хэтрүүлэн нийт 2.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Дэд бүтцийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоол"-ын заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцооны хуудасгүй олгосон зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

## 5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Хангал, Сэлэнгэ, Орхон, Сайхан сумын тархвар зүйч ажлыг хавсран гүйцэтгүүлж, нийт 4 албан хаагчдад 9-12 сарын хугацаанд нийт 7.0 сая төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Засгийн газрын 2029 оны 09 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/342 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль журмыг хэрэгжүүлж, таслан зогсоох албан шаардлага өглөө.

Илрүүлэлт 2: Бичиг хэргийн үндсэн ажилтны батлагдсан цалингийн сангаас хэтрүүлэн цалинжуулахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.4.1 -д "16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 07 дугаар тогтоол "Өндөр насны тэтгэвэртэй холбогдох зарим асуудлын тухай" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн гэрээг хуульд нийцүүлэн байгуулаагүй, тухайн албан тушаалын батлагдсан төсвийг хэтрүүлэн олгосон зөрчлийг арилгаж, таслан зогсоох албан шаардлага өглөө.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Тээвэр шатахууны зардалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Аудитаар шатахуун зарцуулалтад хэрэгжүүлсэн горим сорлын үр дүнгээр автомашины спидометрын заалт зөрүүтэй, жолоочийн тооцооны хуудас бодоогүй, нягтлан бодогч шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй 4.8 сая, шаардах хуудасгүй зарцуулсан 1.3 сая төгрөг нийт 6.1 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын дотоод хяналтыг сайжруулан, анхан шатны баримтын бүрдлийг хангах, жолоочийн тооцооны хуудсыг тогтмол бодож, шатахууны зарцуулалтад хянаж хэвших

#### 2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 30 нэр төрлийн 46.6 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Эрх бүхий албан тушаалтнаас илүү цагаар ажиглуулах шийдвэргүй, албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ илүү цагаар ажиглаж хийсний төлөө 7 удаагийн газрын даргын тушаалаар нэмэгдэл хөлс олгосон.														
Газрын дарга, өөртөө тушаал гаргасан, томилолтын удирдамж, гүйцэтгэл зөрүүтэй, гадаад томилолтыг аймгийн ТЭЗ-аас олгосон байхад 3 удаагийн томилолтын зардал 0.9 сая төгрөгийг давхардуулан олгосон.														
Албан томилолтоор ажигласан 3 албан хаагчдад 0.3 сая төгрөгийн хоол, унааны нөхөх төлбөрийг дутуу олгосон.														
Албан томилолтоор ажигласан 21 албан	1	0.9	1	0.9										

хаагчдад 0.9 сая төгрөгийн хоол, унааны нөхөх төлбөрийг илүү олгосон.																			
Аймгийн Засаг даргын 2025 оны А/815 захирамжаар газрын даргад 2025 оны 12 дугаар сард үр дүнгийн урамшуулал 1.7 сая төгрөгийг олгосон.	1	1.7	1	1.7															
Жолоочийн тооцооны хуудасгүй, анхан шатны баримтгүй, автомашины шатахуун зарцуулах нормыг хэтрүүлэн нийт 2.3 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	2.3	1	2.3															
Хангал, Сэлэнгэ, Орхон, Сайхан сумын тархвар зүйч ажлыг хавсран гүйцэтгүүлж, нийт 4 албан хаагчдад 9-12 сарын хугацаанд нийт 7.0 сая төгрөгийг олгосон					1	7.0													
Бичиг хэргийн үндсэн ажилтны батлагдсан цаглингийн сангаас хэтрүүлэн цаглинжуулахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж ажигласан.					1	6.1													

Аудитаар Шатахуун зарцуулалтад хэрэгжүүлсэн горим сорлын үр дүнгээр автомашины спидометрын заалт зөрүүтэй, жолоочийн тооцооны хуудас бодоогүй, нягтлан бодогч шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй 4.8 сая, шаардах хуудасгүй зарцуулсан 1.3 сая төгрөг нийт 6.1 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан.							1	6.1				
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 30 нэр төрлийн 46.6 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй.							1	46.5				
Дүн	10	89.9	6	24.2	2	13.1	2	52.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------

	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс хавсралт файлыг нэгдүгээр сараас бусар саруудад мэдээлээгүй, холбогдох мэдээллийг хавсралт файл буюу нотлох баримтыг мэдээлээгүй, батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал мэдээлээгүй, бөөн дүнгээр нь мэдээлсэн, байгууллагын ерөнхий мэдээлэл дутуу байна.	1	0.0					1	0.0
<b>Дүн</b>								
	1	0.0					1	0.0
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Халаагч хөшиг нэртэй 380в ажилладаг халаалтын тоног төхөөрөмжийг 2024 онд худалдан авч, тус байгууллага нь 380в зөвшөөрөлгүй 3.8 сая төгрөгийн хөрөнгө өнөөдрийг хүртэл ажиллуулаагүй үр ашиггүй бүртгэлтэй байна.	1	3.8					1	3.8
Гуртын хорио цэврийн тасалт халаалтын зардалд өмнөх онд 5.5 сая төгрөгийн 60м3 мод нөөцлөн бэлтгэсэн, тайлант онд 4.3 сая төгрөгөөр 48м3 мод нэмж худалдан авсан нь зарцуулалтын тайлан байхгүй, норм нормативгүй зарцуулсан байна.	1	5.5					1	5.5
<b>Дүн</b>								
	2	9.3					2	9.3
<b>Нийт дүн</b>								
	3	9.3					3	9.3